



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 06 дугаар сарын 13 өдөр

Дугаар 57

Хэрлэн сум

LVII ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 57 дугаар хуралдаан 2021 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 12:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 100 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1. Дархлаажуулалтын явцын мэдээлэл танилцуулах,

*Эрүүл мэндийн газар*

2. "Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай" аймгийн Онцгой комиссын тогтоолын төсөл танилцуулах,

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар*

3. Коронавируст халдварын нөхцөл байдлын мэдээлэл танилцуулах,

*Эрүүл мэндийн газар,*

*Бүсийн оношилгоо эмчилгээний төв*

4. Хот хоорондын зорчих хөдөлгөөнийг зохицуулах талаар хэлэлцэж шийдвэр гаргах,

5. Аж ахуй нэгж байгууллагуудаас аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлтийг танилцуулах,

*Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар*


ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа-д:

1.1. Хэрлэн сумын дархлаажуулалтын цэгүүдээс Биеийн тамир, спортын газарт зохион байгуулж буй дархлаажуулалтын цэгээс бусад цэгүүдийг буулгах,

Хоёр. Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын  
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

2.1. Улаанбаатар хот болон халдвар голомтлон гарсан орон нутгаас Дорнод аймагт ирж буй дархлаажуулалтын 2 тунд хамрагдаж бүрэн дархлаа тогтох 14

/  /М.Бадамсүрэн  
*Д.Баттулга*

буюу түүнээс дээш хоносон иргэнийг гэрийн тусгаарлалтад 7 хоног шилжүүлэх "Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай" аймгийн Онцгой комиссын тогтоолын төсөлд гишүүдийн саналыг тусгаж батлуулах,

Гурав.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,  
Аймгийн ерөнхий тархвар судлаач эмч, Онцгой комиссын гишүүн Д.Ганганцэцэг нарт:

3.1.Хорих, саатуулах газруудад тандалтын шинжилгээг үе шаттайгаар зохион байгуулах,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа-д:

3.2.Дорнод аймгийн хэмжээнд дархлаажуулалтад хамрагдаагүй иргэдийн судалгааг гаргаж аймгийн Онцгой комиссын даргад танилцуулах,

3.3.Дархлаажуулалтын "Файзер" вакцинд хамрагдах шаардлагатай иргэдийг дархлаажуулалтад шуурхай хамруулахад анхаарч ажиллах,

3.4.Коронавируст халдварын үед ажиллах эрүүл мэндийн байгууллагын хүний нөөц, хүн хүчний судалгааг гаргаж аймгийн Шуурхай штабын дараагийн хуралд танилцуулах,

Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал,  
Онцгой комиссын гишүүн Д.Должин-д:

3.5.Коронавируст халдварын үед ажиллах эрүүл мэндийн байгууллагаас нэмэлтээр ажиллах албан хаагч нарыг дадлагажуулах ажлыг эрчимжүүлэх,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

3.6.Хэрлэн сумын гэрийн тусгаарлалт, ажиглалтад ашиглах зөөврийн камер нэмэгдүүлэх,

3.7.Тусгаарлах байр бэлтгэх ажлын хэсгийг тархвар судлаач эмч ахлан Бүсийн төв Дорнод аймгийн Онцгой байдлын газар, Мэргэжлийн хяналтын газар, Эрүүл мэндийн газар, Цагдаагийн газрын албан хаагч нарын бүрэлдэхүүнтэй байгуулж ажиллах тухай аймгийн Онцгой комиссын тогтоол гаргах,

Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч,  
Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир-д:

3.8.Хэрлэн сумын гэрийн тусгаарлалт, ажиглалтын ажлын хэсгийн 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдөр хүртэл ажиллахад шаардагдах шатахууны зардлыг сумын Онцгой комиссоос шийдвэрлэх,

3.9.Коронавируст халдварын батлагдсан тохиолдлоор бүртгэгдсэн иргэний оршин сууж буй орон сууцны нэг давхрын айлуудыг хамгаалалтад авч лацдах, хяналт тавих зорилгоор зөөврийн камер суурилуулах, хяналтын камер ашиглалтын талаар мэдээлэл танилцуулах,

3.10.Коронавируст халдварын батлагдсан тохиолдлын оршин суугаа байрны хаалганд наах наалтын чанарыг сайжруулж холбогдох зардлыг шийдвэрлэх,

/  /М.Бадамсүрэн  
 /Д.Баттулга



Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга,  
Сууц өмчлөгдчийн холбооны дарга нарт:

3.11.Коронавируст халдвараар батлагдсан иргэний оршин суудаг орцын ариутгал, халдваргүйтгэл хийх ажлыг зохион байгуулах,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа,  
Мэргэжлийн хяналтын газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Д.Мөнхтуяа нарт:

3.12.Коронавируст халдвараар батлагдсан иргэний оршин суудаг орцын ариутгал, халдваргүйтгэл хийх ажилд дэмжлэг үзүүлж ажиллах,

Боловсрол, соёл урлагийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн А.Нансалмаа,  
Дорнод их сургууль, Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв,  
Политехникийн коллеж, Ерөнхий боловсролын сургууль,  
сумын Засаг дарга Онцгой комиссын дарга,  
сумын Соёлын төв, Ерөнхий боловсролын сургуулийн  
дарга, захирал нарт:

3.13.Халдварын тохиолдол нэмэгдэж байгаатай холбогдуулан тусгаарлах байрны эрэмбийн дагуу тусгаарлах байраар ашиглах боломжтой өрөө, тасалгааны бэлэн байдал, бэлтгэл ажлыг хангахад анхаарах,

АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,  
Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ-д:

3.14.Хөлөнбуйр сумын хяналтын цэгт төрийн байгууллагын албан хаагч нарыг томилж ажиллуулах талаар судалж 7 хоногийн дараа аймгийн Шуурхай штабын санал танилцуулах,

3.15.Хэрлэн сум тойрсон хөдөлгөөнт хяналтын цэгүүдэд хууль, хүчний байгууллагуудын албан хаагч нарыг 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд дайчлан ажиллуулах хуваарийг гаргаж батлуулах,

АЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга,  
Онцгой комиссын гишүүн Э.Эрдэнэбилэг-д:


3.16.Сайн дур, иргэний нийгмийн байгууллагуудтай уулзалт зохион байгуулж Коронавируст халдвартай тэмцэх ажилд өөрийн хүсэлтээр ажиллах боломжтой эсэх талаар санал авч аймгийн Шуурхай штабын хуралд танилцуулах,

Дөрөв.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын  
орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

4.1.Хот хоорондын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавих зорилгоор Хэнтий аймгийн "Дэлүүн болдог" хяналтын цэгт томилогдож ажиллах Онцгой байдлын газар, Цагдаагийн газрын 4 албан хаагч нарт 14 хоног ажиллахад шаардагдах байр, хоол, томиллолт, холбоо, шатахууны зардалд нийт 3,330,000 төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газарт олгох,

/ 

/М.Бадамсүрэн

 Д.Баттулга

4.2.Хэнтий аймгийн "Дэлүүн болдог" хяналтын цэгт томилогдож ажиллах албан хаагчдад халдвар хамгааллын хэрэгсэл нэг удаагийн амны хаалт 600 ширхэг, гар ариутгагч /жижиг/ 12 ширхэг, гар ариутгагч /том/ 1 ширхэг, нэг удаагийн бээлий 1 хайрцаг, комбинзон 4 ширхэг, нүдний шил 8 ширхэг, дархлаа дэмжих энергийн ундаа 96 ширхэг, хатаасан аарц 120 ширхэг, цэвэр ус /5л/ 4 ширхэг, цэвэр ус /0,5/ 80 ширхэгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газарт олгох,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,  
Аймгийн Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн цагдаагийн хурандаа Т.Ганзориг,  
Аймгийн ерөнхий тархвар судлаач эмч, Онцгой комиссын гишүүн Д.Ганганцэцэг нарт:

4.3.Хэнтий аймгийн "Дэлүүн болдог" хяналтын цэгт томилогдож ажиллах албан хаагч нарын ажиллах удирдамж боловсруулах, албан хаагч нарт зөвлөмж, зааварчилгаа өгөх,

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Онцгой комиссын гишүүн П.Бат-Өлзий,  
Гаалийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Б.Гэрэлт-Од,  
Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Аюушмаа,  
Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ж.Алимаа,  
Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга, Онцгой комиссын гишүүн Н.Мөнхгэрэл,  
Шүүхийн шинжилгээний албаны дарга, Онцгой комиссын гишүүн, хурандаа Б.Баярбат,  
Статистикийн хэлтсийн дарга Д.Энхбаатар,  
Татварын хэлтсийн дарга С.Бямбарагчаа нарт:

4.4.Аймгийн Шуурхай штабын өргөдлийн багт ээлжийн хуваариар 24 цаг үүрэг гүйцэтгэх боломжтой албан хаагчийг судалж дайчлан ажиллуулах,

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Э.Жавхлан-д:

4.5.Аймгийн Шуурхай штабын өргөдлийн багт хүүхэд хамгааллын чиглэлээр 1 албан хаагчийг 24 цагаар томилж ажиллуулах,

Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын орлогч дарга Ч.Ганбат,  
Аймгийн Засаг даргын орлогч, Онцгой комиссын гишүүн Ш.Ёл,  
Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,  
Аймгийн Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн цагдаагийн хурандаа Т.Ганзориг,  
Тагнуулын газрын дарга, Онцгой комиссын гишүүн,

/С/

/М.Бадамсүрэн

/Д.Баттулга



хурандаа Б.Бямбаа нарт:

4.6. Шуурхай штабын ажиллах журмын дагуу хот хоорондын хөдөлгөөнийг зохицуулах чиглэлээр батлагдсан хуваарийн дагуу 24 цагаар томилогдож ажиллах,

АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга,  
Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ,  
АЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга, Онцгой комиссын  
гишүүн Ц.Баяржаргал,  
АЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга,  
Онцгой комиссын гишүүн В.Цэнгэлмаа,  
Аймгийн Засаг даргын зөвлөх, Онцгой комиссын  
гишүүн Х.Энх-Отгон,  
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын  
гишүүн Ч.Оюунаа нарт:

4.7. Шуурхай штабын ажиллах журмын дагуу аймаг доторх хөдөлгөөнийг зохицуулах чиглэлээр батлагдсан хуваарийн дагуу 24 цагаар томилогдож ажиллах,

АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн  
хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Б.Алтансүх-д:

4.8. Аймгийн Шуурхай штабын өргөдлийн багийг 7 хоногийн хугацаанд хуваарийн дагуу ахалж ажиллах,

Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чойбалсан хотын захирагч,  
Онцгой комиссын гишүүн О.Пүрэв-Очир-д:



4.9. Аймгийн Шуурхай штабын хот, аймаг, сум хоорондын хөдөлгөөнийг зохицуулах ажилд Хэрлэн сумын 11 багийн Засаг дарга нарыг батлагдсан хуваарийн дагуу ээлжээр томилж ажиллуулах,

Аймгийн Шуурхай штабын гишүүдэд:

4.10. Аймгийн Шуурхай штабын ерөнхий зохицуулагч эмнэлгийн тусламж үйлчилгээ 13А, Б, буяны ажил, үндсэн харьяа байнга оршин суух хаягандаа очих, зөвшөөрөгдсөн ачаа тээвэр, үйл ажиллагаа /хөдөө аж ахуй, газар тариалан, жимс хүнсний ногоо тариалах, уул уурхай, газрын тос ашиглалт, эрчим хүч, зам, барилгын бүтээн байгуулалт, засвар үйлчилгээ эрхлэх аж ахуй нэгж/ буюу хүндэтгэн үзэх шалтгаантай иргэнийг судалж нэвтрүүлэх зөвшөөрөл олгох, бусад тохиолдолд Шуурхай штабын хуралд хэлэлцүүлж шийдвэрлүүлэх,


Тав. Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын  
орлогч дарга, хурандаа Г.Нармандах,

5.1. Аймгийн Онцгой комиссын шийдвэрээр Шуурхай штаб, хариу арга хэмжээний баг, хяналтын цэгүүдэд ашиглаж буй үүрэн телефоны утас, гэр интернетийн хэрэглээний зардал нийт 796,300 төгрөгийг сар бүр Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газарт олгох,

/  /М.Бадамсүрэн  
/  /Д.Баттулга

5.2.Вакцин татах ажилд ашиглаж буй аймгийн Цагдаагийн газрын тээврийн хэрэгсэлд хяналтын камер /хар хайрцаг/ суурилуулах зардал 295,000 төгрөгийг Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас Цагдаагийн газарт олгохыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ  
КОМИССЫН ДАРГА  М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА, ДЭД ХУРАНДАА  Д.БАТТУЛГА